

ДеФакто **ТОЙМ**

**ГАЗРЫН ТОС
БОПОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭР**

**АН СҮҮДРИЙН
ЗАСГИЙН ГАЗАР
БАЙГУУЛЛАА**

VI НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Д.СУМЪЯАБАЗАР
Монгол Улсын Их Хурлын гишүүн, Уул
уурхай, хүнд үйлдвэрийн сайд

**2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ БАГТАЖ
УУЛ УУРХАЙН
БИЕ ДААСАН ХУУЛИЙГ
БАТЛУУЛАХААР
АЖИЛЛАЖ БАЙНА**

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

Эдийн засгаа
“ГЭРТ НЬ”

ЭМЧЛЭХ НЬ

Уржигдар Ерөнхий сайд У.Хүрэлсүх
Засгийн газрынхаа эхний 100
хоногийн ажлыг олон нийтэд
тайлагнав.

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.01.31, №32

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn






№416

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>



Эдийн засгаа

“ГЭРТ НЬ”

ЭМЧЛЭХ НЬ

Уржигдар Ерөнхий сайд У.Хүрэлсүх Засгийн газрынхаа эхний 100 хоногийн ажлыг олон нийтэд тайлагнав. Нэг цагийн илтгэлдээ тэр гучин гол ажлаа онцолж, 2016 онд “эрчимт эмчилгээнд” орсон эдийн засгийг 2017 онд “энгийн

тасагт” шилжүүлсэн бол 2018 онд энэ “хүнийг” эмнэлгээс гаргаж, гэрт нь аваачаад, эмчлээд 2019 онд ажилд нь оруулж, 2020 оноос ажлаа хийж, цалинтай тогтвортой ажиллахаар болгоно гэлээ.

ӨНГӨРСӨН 100 ХОНОГИЙН ЭМЧИЛГЭЭ

Давхар дээлтэй 15 сайдтай У.Хүрэлсүхийн Засгийн газар 2017 оны 10-р сарын 20-нд бүрдсэнээс хойш 100 дахь хоног нь 2018 оны 1-р сарын 28-нд тохиов. Хийж эхлүүлсэн ажлуудаас нь макро-эдийн засгийн талаас хоёрыг нь онцолж болох юм.

Нэгдүгээрт нь, төсвийн бодлогод өөрчлөлт орж байна. ОУВС-ийн хөтөлбөрийн дагуу гадаадаас хямдхан зээл орж ирсэн тул Засгийн газар дотоодын банкуудаас өндөр хүүтэй мөнгө татахаа зогсоов. Арилжааны банкууд төрд биш, хувийн салбарт зээл өгөхөөс өөр сонголтгүй болов. Төгрөгийн ханш тогтворжив.

Дампуурсан арилжааны банкуудаас ялгаж үлдээсэн хөрөнгөд суурилсан Төрийн банкны 70 захирлын хагасыг цомхотгов. Энэ банк орон даяар 500 гаруй салбартай, үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг болсон. 2009 онд Засгийн Газрын тогтоолоор байгуулагдсан тус банкны 25 хувийг Сангийн яам, 75 хувийг Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК) эзэмшдэг. Уг нь бол Засгийн газар ч, ХДК ч арилжааны банк эзэмших ёсгүй юм аа. Энэ банкиг хувьчлах ажлын эхлэл гэж харагдаж байна.

Хоёрдугаарт, шатахууны үнийг чөлөөлөх анхны алхам хийгдлээ. АИ80, АИ92 түлшний онцгой албан татварыг цуцалсан нь үнийг төр засаг биш, хэрэглэгч тогтоох зөв чиглэл юм. Шатахууны хангамжийг хараат бус болгохын тулд олон жил яригдсан газрын тосны нэрэх үйлдвэрийн байршлыг тогтоож, Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлттэй зээлээр барьж эхлэх гэж байна.



ИРЭХ 880 ХОНОГИЙН ЭМЧИЛГЭЭ

Ерөнхий сайд “бидний зовлон бол ажилгүйдэл, ядуурал, сахилга хариуцлагагүй, дэг журамгүй явдал” гэж эдийн засгийн өнөөгийн байдлын гол шалтгааныг тодорхойлов.

Тэгээд Засгийн газрынхаа үлдсэн хугацаанд эдийн засгийн зөв менежмент хийнэ. Төрийн албаны бүх шатанд сахилга бат, эмх цэгцтэй байдлыг хангана, 2018 оныг сахилга хариуцлагын жил болгоно. Төсвийн алдагдлыг багасгана. Эдийн засгийн салбар бүрт тодорхой ажлуудыг гүйцэтгэнэ. Жишээ нь агаарын тээврийг либералчилж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Гурван ээлжийн бүх сургуулийг хоёр ээлжтэй болгоно. Тэтгэврийн насыг уян хатан болгоно. Хүн амын орлогын албан татварыг нэмэхгүй,

арван хувиар нь үлдээнэ. Ипотекийн зээлийг үргэлжлүүлж энэ онд 120 тэрбум төгрөг төсвөөс гаргана. Монголбанкинд төвлөрсөн өмнөх зээлийн эргэн төлөлтийн 180 тэрбум төгрөгтэй нийлээд 300 тэрбум төгрөг болно. 2019 оны 4-р сараас эхлээд УБ хот руу ахуйн зориулалтаар түүхий нүүрс оруулахгүй гэх зэрэг амлалт гаргав.

Ерөнхий сайд У.Хүрэлсүх юу хийсэн, юу хийхээ маш тодорхой, эмх цэгцтэй, эрч хүчтэй ярьсан нь энэ Засгийн газар онцгой их асуудал шийдэх байх гэсэн томоохон хүлээлт бий болгов. Гэвч энэ бүхнийг төр, хувийн хэвшлийн аль нь хийх, ер нь яаж хийх, яаж зах зээлийн механизмыг өөрийг нь ашиглах тухай бараг ярьсангүй.

ЭМЧЛЭХ АРГА

Ерөнхий сайдын эдийн засгийн байдалд тавьсан оношилгоо нь зөв ч, яаж эмчлэх арга нь тодорхой бус, шинжлэх ухааны үндэслэл багатай санагдлаа.

Сахилга батгүй, хариуцлагагүй байдал бол шударга ёс, хуулийн засаглал тогтохгүй байгаагаас үүдэлтэй. Төр засагт бий болсон авлигыг дарахаас эхэлж шударга ёс тогтох юм аа. Авлига нь улс төрийн намуудын санхүүжилтээс эхтэй бөгөөд төрийн эрх барьж буй намын даргын хувьд Ерөнхий сайд та, намынхаа УИХ-ын 65 гишүүн, түүний дотор 15 сайд-гишүүнийхээ хүчээр улс төрийн намуудын тухай хуулиа яаралтай шинэчлэх ёстой. Мөн нийтийн хөрөнгийг завшиж, луйвардсан этгээдүүдтэй нам, төрийн харьяаллаас үл хамааран түргэн шуурхай хариуцлага тооцохгүйгээр шударга ёс ирэхгүй.

Та зөвхөн Улаанбаатар хотын газрыг, ялангуяа Богд уулын амууд, Туулын эрэг, Яармагийн талбайн газрыг хэн, яаж зувчуулсныг ил тод болгож, нийтийн хөрөнгийг буцаах, эсвэл төлбөрийг нь авчихад л авлигын хагас нь цэгцэрнэ.

Загас, төр хоёрын ялгаа бол загас дээрээсээ ялзардаг ч, доороос нь цэвэрлэдэг, харин төр дээрээсээ ялзарсан болохоор тэндээс нь цэвэрлэх ёстой. Тэгээд ч та 100 хоногийн өмнө “Би айхгүй, амь насаа алдахаас ч айхгүй. Ганцхан зүйлээс айна. Ард түмний минь итгэл найдвар алдрах вий гэхээс л айж байна” гэсэн шүү дээ.

Ажилгүйдэл, ядуурал бол эдийн засагт төрийн оролцоо дэндүү их болсон, төрийн компаниуд чинь намынх болчихоод, бүгд алдагдалтай учраас боловсрол, эрүүл мэндэд зориулах ёстой байсан улсын төсвөөс тэжээлгэж байгаатай холбоотой. Төрийн компаниудыг намын гишүүддээ биш, нийт иргэддээ хувьцаат компани болгоод өгчих өө. Уул уурхай, агаарын болон төмөр зам, ус цахилгааны бүх компаниудын 60 хувийг эхлээд хувьчлах шаардлагатай байна.

Эцэст нь бүх үнийг бүрэн чөлөөлж, “Үнийн зөвлөл” гэгчээ татан буулгаад тараачих аа. Шударга өрсөлдөөнийг дэмжээд, төр засгийн удирдлагуудаа компаниас нь холдуул аа. Тэгвэл таны хийх гээд байгаа эдийн засгийн бүх шинэчлэлийг зах зээл өөрөө хийгээд өгнө. 15 сайд чинь гучин нүдтэй, ард түмэн чинь зургаан сая нүдтэй учир бүхнийг харж чадна.

За энэ гурван зүйлийг та хийж, эхлүүлж чадвал ард иргэд чинь таны хэлснээр “элбэг хангалуун, аз жаргалтай” амьдарч эхэлнэ.

2018.01.31



Д.СУМЪАБАЗАР

Монгол Улсын Их Хурлын
гишүүн, Уул уурхай, хүнд
үйлдвэрийн сайд

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ БАГТАЖ **УУЛ УУРХАЙН** БИЕ ДААСАН ХУУЛИЙГ БАТЛУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

Д.Сумъяабазар нь Бизнесийн удирдлагын мэргэжил эзэмшсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр 2008-2012 онд ажилласан ба Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн МАН-ын хороон дарга, МАН-ын бага хурлын гишүүний албыг хашдаг. 2016 онд МУ-ын Их Хурлын гишүүнээр 2 дахь удаагаа сонгогдсон ба 2017 оноос Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ажиллаж байна.

Д.Ж: Сайн байна уу, та. Давхар дээлтэй сайд байх ямар байна вэ?

Д.С: Маш их ачаалалтай байна. Гэхдээ хувь хүн цагийн менежментээ хэрхэн зохицуулахаас бүх зүйл шалтгаалж байна. УИХ болон Засгийн газрын ажлыг давхар хийнэ гэдэг нь хувийн зохион байгуулалт, сахилга баттай байхаас шууд хамаарч байна. Сайшаал, шүүмжлэл зэрэг ирдэг учраас тэр бүхэнд хурцлагдаж, улам “дархлаа” суулгаж өгч байна.

Д.Ж: Монгол улсын уул уурхайн хууль 10 жилийн дотор 250 удаа өөрчлөгдсөн байна. Одоо та бүхэн бас өөрчлөлт хийх юм байна. Юуг нь өөрчлөх юм бэ?

Д.С: Татвартай холбоотой асуудлууд их орж ирдэг юм. Орон нутагт ашигт малтмалын нөөц ашигласны татвар гэж 30 хувийг нь өгөх хэрэгтэй, Сангийн яамнаас нэгдсэн байдлаар орлогыг татчихаад буцаагаад тэр мөнгийг хуваарилах зохицуулалт хэрэгждэггүй байх шалтгаанууд, эсвэл гадаадын хөрөнгө оруулалтаас авч байгаа татварын хувь хэмжээг өөрчлөх, аль болох Монгол улсад өгөөжтэй байх ёстой гэх үүднээс УИХ-ын гишүүд их олон өөрчлөлт, төслүүдийг оруулсан байдаг. Уул уурхайн салбарын эрх зүйн орчин маш тогтвортой байх ёстой. Татвараас ашиг олохоос илүүтэйгээр ажлын байр нэмэгдүүлэх болон бусад татваруудаас ашиг олох тал дээр анхаарах ёстой.

Д.Ж: Одоо яагаад тийм байж чадахгүй байна вэ?

Д.С: Уул уурхайн яам үүнийг гүйцэлдүүлэхийн төлөө цаг, наргүй ажиллаж байна. 2018 оны эхний хагаст багтаж уул уурхайн бие даасан хуулийг батлуулах төлөвлөгөөгөөр манай яамны хуулийн хэлтэс, ашигт малтмал, газрын тосны агентлагийн ажилтнууд мөн Адам Смитийн сан зэрэг байгууллагуудаас техник, арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллаж байна. Хамгийн гол нь уул уурхайн салбарын тогтвортой байдлыг хэрхэн хангах вэ гэдэг дээр ажиллаж байна.

Д.Ж: Орон нутагт уул уурхайг зөв ойлгохгүй, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад дарамт үзүүлдэг зэрэг иргэдийн бухимдлын цаад шалтгаан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 30 хувь нь орон нутагт очихгүй байгаатай холбоотой. Энэ 30 хувь иргэдийн гар дээр очихгүй байгаа болохоор уул уурхайн салбарын нэр хүнд иргэдийн дунд унаж байна. Та УИХ-ын гишүүн болон сайдын хувьд энэ асуудлыг шийдэхээр яг юу хийх вэ?

Д.С: Баялгийг нь авчихаад буцаагаад хуваарилалтыг нь зөв

хийх ёстой. Хууль нь батлагдчихсан хэрнээ хэрэгжилт муутай байгаад орон нутгийн удирдлагууд болон иргэд шүүмжлэлтэй байгаа. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 30 хувийг орон нутагт нь үлдээх журмаа боловсруулаад, яамдуудаас санал хураагаад, Засгийн газрын хуралдаанаар ороод батлуулаад журмаараа зохицуулагдаад явах ёстой.

Д.Ж: Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаагаа хэзээ жигдрүүлэх юм бэ?

Д.С: Тусгай зөвшөөрөл олгох тухай асуудал иргэдийн хардалт, сэрдэлтийн дунд байдаг. Зохион байгуулалтад орсон хэсэг бүлэг хүмүүсийн сонирхол, бүлэглэлд автсан байдлаар уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон ашигт малтмал, газрын тосны газар байнга хардалтад өртөж байдаг.

Д.Ж: Та үүний талаар ямар арга хэмжээ авч байна вэ?

Д.С: Цахимаар тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудал үүссэн тул түр хаасан. 2000 гаруй аж ахуй нэгжүүд өргөдөл илгээсэн байсны зарим нь сервер дээр гадны нөлөө орсноос болж гацсан. Тиймээс үүнийг цэгцэлж, нээлттэй сонгон шалгаруулалт хийх бүр болохгүй бол дуудлага худалдаагаар явуулах арга хэмжээ авах нь зүйтэй юм байна гэдэг зохицуулалтаар тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журам боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар батлуулах гэж байна.

Д.Ж: Та сайд болмогцоо олон уул уурхайн үйлдвэрүүдээр явсан. Тавантолгойн бүлэг ордоос Гашуун сухайтын боомт хүртэлх том асуудал гараад 160 км автомашины цуваа үүсч 6000 хүнийг 2 долоо хоног зогсоосон. Энэ асуудлыг та яаж шийдэх гэж байна вэ?

Д.С: БНХАУ-ын талтай улс төрийн хүрээнд ойлголцож, хил гаалийн нэвтрэх чадварыг сайжруулах талаар ярилцах ёстой. Гэхдээ бид нэг боомтоор төмөр зам, авто зам болон асфалтан зам гэж зэрэг гардаг байж болохгүй. Хэрвээ хилийн гарц багасгах хэрэг гарвал бид цаашдаа хаачихуу гэдэг хувилбартай байх хэрэгтэй. Тэгэхийн тулд бид Ханги-Мандал болон Цагаан дэл рүү явж байгаа нүүрсний борлуулалта бусад аймаг руу өгье, Өвөр Монголын бусад аймгууд руу гарцтай болъё.

Д.Ж: Өвөр Монголын боомтууд нээгдчихсэн хэдий ч замгүй байгаа. Төмөр замыг яах вэ? Хэзээ тавьж эхлэх вэ?

Д.С: Төмөр замыг Гашуун сухайтаар л тавина. Өөр гарц байхгүй. 2018 онд бүх ажлыг эхлүүлнэ гэж бодож байгаа. Төмөр

зам болон Тавантолгойн бүлэг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад цогц асуудлыг шийднэ гэж оруулж ирж байгаа. Нэгдүгээрт, үйлдвэрлэлийн усан хангамжийн асуудал байгаа. Түүнчлэн цахилгаан станц, баяжуулах үйлдвэр болон төмөр замын асуудлууд байгаа юм.

Д.Ж: Эдгээр асуудлуудыг хэзээ шийдэх юм бэ?

Д.С: 2-р сараас бүх ажлууд эхэлнэ дээ.

Д.Ж: Оюу толгойн үр ашгийг нэмэгдүүлэх тал дээр хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийнэ гэж байна. Оюу толгойн гэрээг өөрчлөх хэрэгтэй гэж танай орлогч сайд Д.Загджав саяхан мэдэгдэл гаргасан. Энэ талаар юу гэж бодож байна вэ?

Д.С: Оюу толгойн гэрээг зогсооно, үндсээр нь өөрчлөх гэдэг хэцүү. Энэ бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны байр суурь биш, Монгол улсын Засгийн газрын ч байр суурь биш. Олон улсын байгууллага, гэрээ конвенцын хүрээнд хүлээгдсэн үүрэг, Монгол улсын хууль тогтоомж гэж байгаа. Хууль зөрчсөн, бидний сайжруулах зүйл байгаа, үүнийг үгүйсгэхгүй. Гэхдээ үүнийг талууд ярилцаж, хэлэлцэж байж зохицуулах ёстой гэдэг байр сууриа бид хэлэлцээрийн шатнаас эхлээд илэрхийлээд явж байгаа. Жишээ нь, Монгол улс гэрээнд хүлээсэн үүргээрээ 4,4 тэрбум доллар босгочихсон, дээрээс нь 1,6 тэрбум доллар босгох хэрэгтэй. Эхний санхүүжилт болох 600 сая долларын асуудлыг яриад бид хэсэгчилсэн байдлаар зохицуулах ёстой гэсэн байдлыг шахаж байж Засгийн газрынхаа байр суурийг хамгаалж гарсан. Эхний ээлжинд 100 сая долларын санхүүжилт өгөхөөр болсон. 100 сая долларын санхүүжилтыг цаашдаа нимгэн капиталжуулалт буюу 1*3 гээд 600 сая нь 1,8 тэрбум болоод, ахиад 600-г нэмэхээр 2,4 тэрбум долларын санхүүгийн эх үүсвэрийг Рио Тинтод өгөх боломжтой болно гэсэн үг. Тэгэхээр 100 сая гэдэг бол 300 сая долларын эрхийг өгч байна гэсэн үг. Бидний байр суурь бол Оюу толгойтой хэлэлцээрийн түвшинд зардлаа бууруулах, өгөөжөө нэмэгдүүлэх. Өчигдөр гэхэд Рио Тинтогийн тэргүүн дэд захиралтай уулзаад зарчмын байр суурь, Засгийн газрын байр сууриа илэрхийлсэн. Монгол талын өгөөжийг нэмэгдүүлэх ёстой, Оюу толгойн зардлыг бууруул, зардал өсч байгаа тал дээр ТУЗ-ийг идэвхтэй ажиллуулахад би шахах болно гэх зэргийг тохиролцлоо. ТУЗ-д 3 хүн ажилладаг бөгөөд маш сайн ажиллаж байж, мөн хувьцаа эзэмшигч нь Засгийн газарт бодит мэдээллийг өгч байж, цаашдаа аль аль талдаа асуудлаа яаж зохицуулах вэ гэдэг гарц, гаргалгааг шийдэж байж бид нарын том төсөл явах ёстой.

Д.Ж: Оюу толгойн гэрээнд өөрчлөлт оруулна гэсэн үг үү?

Д.С: Оюу толгойн гэрээг ярилцана. Чухам аль хэсгийг гэдэг нь тодорхойгүй байхад гэрээг өөрчлөхгүй.

Д.Ж: Та саяхан гадаадын хөрөнгийн бирж дээр байгаа монголын орд газрыг түшиглэсэн компаниудыг монголын зах зээл дээр хувьцаагаа гаргаач гэж байсан. Энэ ажил ямар түвшинд байна вэ?

Д.С: Бид уул уурхайн баялаг, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ёстой гэсэн суурь зарчмаа баримталж явна. Засгийн газрын хуралдаан гэдэг бол хувьцаа эзэмшигчдийн хуралдаан. Монгол улсын Засгийн газар бол бүх

том төслүүдийн хувьцаа эзэмшигч юм. Ард нь иргэддээ ноогдол ашиг хуваах, баялгийн сангийн бүтэц зохион байгуулалтад нэн яаралтай орох хэрэгтэй. Тэгэхийн тулд Эрдэнэс Монголыг “холдинг”-ийн бүтэц, зохион байгуулалтад оруулаад, хажууд нь баялгийн санг байгуулах хэрэгтэй. Бид ирээдүйн өв сангаа баялгийн сан гэж андуураад байгаа. Уг нь хоёр өөр зүйл. Тиймээс баялгийн сангийн тухай хуулийг яаралтай оруулж ирэх ёстой.

Д.Ж: Уул уурхай өндөр хөгжсөн орнууд баялгийн санг иргэддээ тараахгүйгээр томруулж байгаад төсвийн алдагдалтай үедээ хэрэглэдэг жишээнүүд ч байдаг шүү дээ.

Д.С: Тийм, боломжтой. Бид дүрмээрээ л зохицуулж өгөх хэрэгтэй. Хүмүүс намайг буруу ярьж байна гэж магадгүй. Ерөнхий сайд нь Эрдэнэс Монголын нэгдлийн дарга байх ёстой юм байна гэдэг ойлголт л тархи руу орсон. Арабын том баялгийн сангуудыг Ерөнхий сайд, Ерөнхийлөгч нь, Норвегийн тэтгэврийн санг Сангийн сайд нь удирдаж Ерөнхий сайд нь хяналт тавьдаг гээд төр өмч дээрээ эзэн нь байдаг юм байна. Гэтэл манайд өмчийн бүртгэл гэж байдаггүй. Эрдэнэс Тавантолгойн 1072 ширхэг хувьцаа байгаа гэж байгаа боловч эксаль файл дээр бүртгэлтэй, актив талдаа бүртгэсэн боловч пассив талдаа бүртгээгүй байдаг.

Д.Ж: Хувьцаат гэдэг компаниараа яваад, хувьцааг нь зардаг болвол яасан юм бэ?

Д.С: Яг үнэн. Төр хяналтаа тавина. Жишээ нь Эрдэнэс таван толгойн 20-30 хувийг өөрийнхөө хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлийн систем ашиглаад бусад улсууд руу зарах эрх нь байна.

Д.Ж: Үүнийг хийхэд танд юу хэрэгтэй байна? Хэзээ хийх үү?

Д.С: Би ерөнхий схем, бүтцийг нь гаргачихсан, ажлын хэсэг товлочихсон бөгөөд бүгдийнх нь саналыг аваад явж байгаа. Хөрөнгийн биржээрээ дамжаад үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, санхүүгийн зохицуулах хороо үүнд идэвхтэй ажиллах ёстой. Баялгийн салбар санхүүгийн салбарын уялдаа холбоог хангасан зохион байгуулалтад бид яаралтай орох ёстой.

Д.Ж: Монгол улсын уул уурхайн салбарын том төслүүдийг төр гүйцэтгэсэн нь дээр үү, хувийн компани уу?

Д.С: Төр манлайлж явах ёстой. 100 хувь төрийн өмчийн компани байж огт болохгүй учраас хувьцаат компани байх ёстой. Ард иргэддээ олгох давуу эрхийн хувьцааг нэг талдаа, энгийн хувьцаагаа хэдэн тэрбум ширхгийг гаргахаа нөгөө талдаа гаргачих. Түүнээсээ харж байгаад гадныханд хөрөнгө босгохдоо ямар хэмжээний хувьцааг ямар үнээр гаргахаа тодорхойлох хэрэгтэй. Энэ бол дэлхийн сонгодог жишээ бөгөөд бидэнд үүнээс өөр ямар ч гарц байхгүй.

2018.01.13

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/d-sumiyaabazar-sumiyabazar-dolgorsuren> холбоосоор үзнэ үү.

Татгалзахын аргагүй САНАЛ

FORD EXPLORER | JAGUAR F-PACE | RANGE ROVER

ШАТАХУУНЫ ЭРХ | ӨВЛИЙН ДУГУЙ

АЯЛАЛЫН ЭРХ | СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ

Холбоо барих: 99118301, 99106507, 99118375
www.waa.mn

WAGNER ASIA AUTOMOTIVE LLC



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2018.01.28-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://fargaldefacto.com/category/12>

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР



2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар Дорноговь аймгийн Алтанширээт сумын нутагт 150 га талбайг тусгай хэрэгцээнд авахаар шийдэж, уг газраа газрын тос боловсруулах үйлдвэр барих гэнэ. Ингэхдээ Сайншандаас газрын тос боловсруулах үйлдвэр хүртэл 20 км төмөр зам, хүнд даацын автозам, эрчим хүч дамжуулах шугамын төслийн ажил зэргийг хийж гүйцэтгэхээр болсон байна.

ТЭЗҮ буюу техник, эдийн засгийн үндэслэлийг нь Энэтхэгийн компани хийж байгаа юм байна. Эхний байдлаар бол болно гээд гаргасан. Нарийвчилсан тооцоогоо 3-р сард өгнө. Өнгөрсөн оны 12-р сард Энэтхэгийн "Engineering India Limited" гэсэн төрийн компаниурьдчилсан байдлаар, цаг алдахгүйгээр Монгол улсад ирж бидэнд шаардлагатай бүтцүүдийг тодорхойлж 20км битон зам, 20км Сайншандаас Алтанширээт хүртэл төмөр зам хэрэгтэй байгаа тухай яриад ажлаа эхлүүлж байсан. Өмнө нь энэ ажлыг эхлүүлэв, Энэтхэгийн зээлээр барина гээд зөндөө ярьж байсан л даа. Гэхдээ энэ удаа харьцангуй бодитой хийгдэж байгаагийн гол шалтгаан нь Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг 2015 оны 5-р сарын 17-нд Ерөнхий сайд Narendra Modi монголд айлчлахдаа бидэнд амласан зээлийг нээж байгаа юм. 2016 онд шийдвэр гарахгүй байж байгаад 2017 онд яг энэхүү газрын тосны үйлдвэрийг барина гэдэг шийдвэр гарсан. Энэ хэлэлцээр үргэлжилсээр Энэтхэгийн компани судалгаагаа хийгээд дуусаж байгаа юм байна. Ингэснээр Энэтхэгийн талын хөрөнгөөр буюу тэдний оролцоотойгоор барина гэсэн үг. Мөн энэ үйлдвэрийг байгуулснаар давуу тал нь юу юм бэ гэсэн асуулт гарна. Энэ нь 100% Орос улсаас хамаардаг газрын тосны бүтээгдэхүүний хараат байдал багасна гэсэн үг. Нөгөө талаас Монгол улс экспортоор олсон орлогынхоо 1/5-г буюу 20%-ийг Орос улсаас газрын тос авч шатаадаг байсан бол энэ хувь нь өөр зүйлд зарцуулагдана гэсэн үг юм. Харин сул талын хувьд бид Хятад улсад Монгол улсад газрын тос хуваах гэрээгээр газрын тос олборлож байгаа. (Уг нь нэг Америкийн компани олсон боловч дараа нь хувьцааг нь Хятадын компани худалдаад авсан юм) Тэгээд гэрээний дагуу Хятад улс газрын тос авч байгаа ба авсан газрын тосныхоо тодорхой хувийг монголд өгч байгаа, мөн цаашаа олон улсын зах зээл дээр гарч байгаа хэсгийг

нь олон улсын үнээр нь худалдаж авах эрхтэй. Үүнийг тооцохоор 600 км газар шугам хоолой тавина гэсэн үг. Энэ мэдээж үнэтэй болохоор монголын нөөц ямар түвшинд байгаа вэ гэдэг асуулт гарна. Хятадын газрын тосны амлаж байгаагаар бол 2020 он хүртэл бид нар жилийн 1 сая тонн түүхий газрын тос олборлох төдийгүй 2040 он хүртэл 1,5 сая тонныг олборно. Ийнхүү харахад харьцангуй нөөц байна гэж үзэж байна. Мөн Өмнөговь Ханбогд суманд газрын тосны 11-р талбай гэж байдаг. Тэнд 11-н өрөмдлөг хийгээд газрын тос илэрсэн байгаа. Энэ бүхнээс харахад манай улсад өөрсдийн түүхий газрын тосны нөөц байна гэж хэлж болохоор байгаа юм. Тэгээд манай улсын газрын тос илүү өтгөн (viscosity гэж нэрлэдэг) тул тэр 600 км хоолойн тодорхой хэсэгт нь халааж тодорхой хэсэгт нь шахдаг станцууд байхаар бүх тооцоо нь гарчихсан байгаа юм байна. Мэдээж газрын тосыг хоолойгоор шахах нь үнэтэй ч гэсэн хамгийн ашигтай хувилбар юм.

Одоо бол Дорноговь аймгаас Тамсаг, түүнээс наашаа 600 км зайд Алтанширээ байгаа. Алтанширээ дээрээ нэрэх үйлдвэрээ байгуулаад, 20км Сайншандтай холбосон төмөр замаар өөрсдийн гэрээнийхээ газар руу явуулна гэсэн үг л дээ. Алтанширээт сумыг сонгосны учир нь Сайншандад байгаа хамгийн ойрхон, гүний усны нөөц нь газрын тос нэрэх үйлдвэр барьж болох ганц газар юм. Мэдээж газрын тосны нэрэх үйлдвэрт маш их хэмжээний ус шаардлага байдаг. Үүний бас нэг онцлог нь цоо шинэ химийн аж үйлдвэрийг бий болгож байгаа юм. Яагаад гэвэл газрын тосыг нэрэхээр 40% эсвэл 50% нь дизель болно гэж үзэж байгаа. Үүнээс үлдсэн хувь нь метан гэх мэт органик химийн хий болон гардаг. Тэр бүхнийг тус тусад нь ялгаж аваад, өөр өөрийнх нь чиглэлээр полимерийн задаргаа хийдэг үйлдвэр хэрэгтэй болно. Тэгэхээр эхний ээлжид зардал нь бага ч гэсэн хими технологийн иймэрхүү үйлдвэрийн суурь тавигдах юм бол бид нар зарим бүтээгдэхүүнээ, жишээлбэл гялгар хүүдий гэх мэт төрлийн бүтээгдэхүүнийг дотроо үйлдвэрлэх боломжтой.

Монгол улс одоогийн байдлаар 1,3 сая тонн газрын тос авч байна. Өмнөх жил 1,2 сая тонныг авч байсан. Бас энэ авч байгаа бүх газрын тосны 40% нь дизелийн түлш байдаг. Тэгэхээр дизелийн түлшийг эндээс авах юм бол хамаарал багасна гэж үзэж байгаа. Мөн Ерөнхий сайд У.Хүрэлсүх "Газрын тос нэрэх үйлдвэрийг байгуулах ажлыг биечлэн хариуцна, дотроо хяналтын хэсэг гаргана. Үүн дотор авлигатай тэмцэх газар, цагдаагийн ерөнхий газар, тагнуулын ерөнхий газар, мэргэжлийн ерөнхий хяналтын газруудаас бүрдсэн баг бүрдүүлж ажиллана" гэж их хүчтэй мэдэгдэл өнгөрсөн 7 хоногт хэлсэн.

АН СҮҮДРИЙН ЗАСГИЙН ГАЗАР БАЙГУУЛЛАА



Ардчилсан намын дарга С.Эрдэнэ АН 16 бодлогын зөвлөл байгуулж сүүдрийн засгийн газраар ажиллахаар болсноо зарлалаа. Өөрөөр хэлбэл Уул уурхай,

эрүүл мэнд, боловсролын гэх мэт чиглэлүүдээр ажиллахаар болсон гэнэ.

Одоогоор бодлогын ерөнхий зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн даргаа томилжээ.

Улс төрийн хүчин хүчтэй байвал ардчилал бэхждэг. Манай намуудад “бүхэл байх”(integrity) гэдэг тусгай зарчим байдаггүй. Энэ нь үг, үйл нь давхцаж байх ёстой гэсэн утгатай. Тийм болохоор зарчим дээр суурилагагүй тул юу ч байгуулсан, сайн ажиллахгүй байна. Ер нь манай намууд хийх гэж байгаа ажлаа сүржин зарладаг.

Тэгээд тэгсэн эсэх нь эргэлзээтэй. Ер нь бол сүүдрийн засгийн газрын зорилго бол нарны засгийн газраа устгах, огцруулах, алга болгохдоо биш юм. Шийдэж байгаа асуудал нь яг ард түмний эрх ашигтай нийцэж байна уу? Яавал илүү зохицуулах вэ гэдэг үүднээс хандах хэрэгтэй. Энэ 16-н бодлогын зөвлөл гэдэг нь яамны тоогоор гарч байгаа. 16-н ирээдүйн яамныхаа сайдыг одоо бий болгох гэсэн оролдлого, одоо томилж байгаа хэрэг гэж би бодож байна. Гэхдээ тэр зөвлөлийн дарга болохын тулд хэдэн төгрөг өгч байгаагаа зарлах хэрэгтэй. Бүх мөнгө өгсөн хүнд албан тушаал нь хүрэхгүй болохоор шинэ албан тушаал бодож гаргаад л бид нарын толгойг үнэхээр эргүүлж байна.

Монгол улс хөгжиж чадахгүй байгаа хамгийн том шалтгаан бол улс төрийн институт тогтож, бэхжиж

чадахгүй байна. Энэ 2 бэхжихгүй бол яадаг, бэхжихээр яадаг гэдгийн тод жишээ бол Өмнөд Солонгос, Хойд Солонгосын хөгжлийн түүх шүү дээ. Өнөөдөр бид нар Хойд Солонгос тал руугаа илүү ойрхон байгаа. Учир нь улс төрийн институт нь хөгжихгүй байгаа. Үүнийг нарны ч бай, сүүдрийн ч бай засгийн газар нь бодмоор байгаа юм.

АН нарны засгийн газартай байхдаа Монгол улсыг ерөнд живүүлсэн шүү дээ. Үүнийхээ хариуцлагыг огт ярихгүй байгааг аль аль нь харах хэрэгтэй. Ер нь энэ 2 нам эвсэж байснаас өрсөлдөж байсан нь дээр юм байна лээ. Эвсэхээрээ хамаг гэмт хэргээ нуугаад, тохиролцоод, хаагаад хана бий болгочихож байгаа юм. Ийм болохоор “Ард түмэн мэдлэгтэйгээр, мэдээлэлтэйгээр энэ 2 намтай харьцаж, ялангуяа мөнгө, төгрөг нь хаана байгааг гаргахгүй бол Монгол улс хөгжихгүй, эдийн засаг хямраад л байна” гэдгийг дахин хэлмээр байна.

Мэдээж удирдаж байгаа хүмүүс мэдлэг боловсрол сул болохоор Паркинсоны хуулиар: Нэг сул удирдагч хоёр сул орлогчтой болдог. Яагаад гэвэл хүчтэй болчих юм бол өөрийг нь үгүй хийнэ. Тийм болохоор өөрөөсөө сул 2 хүн авч байгаа юм. Тэгээд цаашаа 2 сул хүн нь өөрөөсөө сул хүн авна. Тэр нь өөрөөсөө сул хүн авна гэх мэтээр явсаар байдаг гэдгийг Паркинсон гэдэг хүн дээр үед Англи улс авлига ихтэй байх үед гаргаж ирж байсан юм. Энэ хуулиар сул дарга нар чинь доороо 2 өөрөөсөө сул хүн аваад байхаар борооны дараах мөөг шиг л олширч байгаа юм.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh18-sh1-28> холбоосоор үзнэ үү



NEW NISSAN PATROL

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84** сар

УРАМШУУЛАЛ:



Хамгаалтын хууль



Сэлбэг сервисын эрх



4x4 Өвлийн дугуй



Салонины шийтний хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая

THE ECONOMIC CLUB

OF ULAANBAATAR



Ч.ОТГОЧУЛУУ
Эдийн засагч

ДЭЛХИЙН ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ч.Отгочулуу нь Оюутолгой компанийн ТУЗ-ийн гишүүн, Ерөнхийлөгчийн зөвлөх зэрэг улстөрийн болон эдийн засгийн олон чухал ажлуудыг хийж байсан туршлагатай мэргэжилтэн.

ХӨТӨЛБӨР

07:30-07:40

Бүртгэл ба өглөөний цай

07:40-07:45

Нээлтийн үг: УБ
эдийн засгийн
клубын Ерөнхийлөгч
Д.Жаргалсайхан

07:45-08:20

Илтгэл: Эдийн засагч
Ч.Отгочулуу

08:20-08:30

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: Асуулт,
хариулт

Уулзалт Монгол хэл дээр явагдана

ХЭЗЭЭ:

2018.02.06-ны
Мягмар гараг

07:30-09:00

цагийн хооронд болно.

ХААНА:

Гранд Хан Айриш паб, 2
давхарт, Чингис танхим
(УДЭТ-хажууд байрлах)

ТӨЛБӨР: 20,000 төгрөг (Уулзалт болох өдөр бэлнээр төлнө)

ХОЛБОО БАРИХ:

Цахим шуудан: origo@jargaldefacto.com

Холбогдох утас: 9400-3369

Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан

Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа

Баг: Батхүүгийн Амар

Отгонсүрэнгийн Билгүүн

Өсөхбаярын Биндэръяа

Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn